



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/34

Улаанбаатар хот

“Монгол улсыг гадаадад сурталчлах хөтөлбөр”-ийн 2017 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Засгийн газрын 2016 оны “Хөтөлбөр батлах тухай” 2 дугаар тогтоол, газрын дүрмийн 2.5.3 заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монгол улсыг гадаадад сурталчлах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх 2016-2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу тус газраас 2017 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай

2. Төлөвлөгөөний биелэлтийг тайлагнан ажиллахыг Захиргааны хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Ганболд/, Бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Э.Батжаргал/, Мэдээлэл сурталчилгааны хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Г.Гансүвд/ нарт төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавин ажиллахыг Орлогч даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Энхтүвшин/-д даалгасугай.

ДАРГА *D. Batkhuyag* Д.БАТСҮХ



1150500138

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2017 оны 04 сарын 17-ны
едрийн А/34 дугаар тушаалын хавсралт



“МОНГОЛ УЛСЫГ ГАДААДАД СУРТАЛЧЛАХ ХӨТӨЛБӨР”-ИЙН
2017 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2017 оны 4 дүгээр сарын 17

Улаанбаатар хот

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх үр дүн	Хэрэгжилт	Хариуцах хэлтэс	Хугацаа
ДӨРӨВ. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД:					
1	Улаанбаатар хотод өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор “Улаанбаатар өвлийн наадам” арга хэмжээг зохион байгуулах	Гадаад, дотоодын иргэд, жуулчдыг өргөнөөр хамруулж өвлийн олон төрөлт арга хэмжээнүүдийг зохион байгуулсан байна.		БТХ	1-р улирал
2	ХБНГУ, ОХУ, БНХАУ, БНСУ, Япон болон бусад улсуудад зохиогддог олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд нэгдсэн зохион байгуулалтаар оролцож, сурталчлах	Улаанбаатар хотыг болон тус газрын зүгээс аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр хийж хэрэгжүүлж буй ажлыг сурталчилсан байна		МСХ	Жилдээ
3	Цайны замын аялал жуулчлалыг хөгжүүлэх хүрээнд “Монгол, Орос, Хятад гурван улсын эрдэм шинжилгээний бага хурал болон соёлын	Аялал жуулчлалын зах зээлийг хамтран хөгжүүлж, шинэ брэнд бий болгох, 3 улсын соёлын аялал жуулчлалыг хөгжүүлсэн байна.		БТХ	3-р улирал

	фестивалийг зохион байгуулах /Монгол улс, БНХАУ, ОХУ/				
4	Нүүдлийн аялал жуулчлал” олон улсын хурлыг Улаанбаатар хотод зохион байгуулах	Тус газрын зүгээс зохион байгуулалтын ажилд оролцох ба сурталчилгааны материал, мэдээ, мэдээллээр хангасан байна.		БТХ	Жилдээ
5	Зүүн хойд Азийн бүс нутгийн шууд нислэгтэй, хүн ам олонтой, харилцаат хотуудад Улаанбаатар хотын аялал жуулчлал, соёл урлагийн өдрүүдийг төмөр зам, агаарын тээврийн компаниуд, аялал жуулчлалын байгууллагуудтай хамтран жил бүр зохион байгуулах	БНХАУ-ын Хонконг, Тайвань, ӨМӨЗО олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцож Улаанбаатар хотыг сурталчилсан байна.		БТХ	Жилдээ
6	Аялал жуулчлал маркетинг сурталчилгаанд интернет, нийгмийн сүлжээ, мэдээллийн технологийн дэвшлийг түлхүү ашиглах	Улаанбаатар хотын аялал жуулчлалын мэдээллийн сайтын илэрцийг нэмэгдүүлэх /SEO-search engine optimization/ ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн байна.		МСХ	Жилдээ
	Улаанбаатар хотод ирж буй жуулчдын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн “Медиа аян”-г зохион байгуулах.	Маркетинг сурталчилгааг өрнүүлснээр жуулчдын сэтгэл ханамжийг нэмэгдүүлсэн байна.		МСХ	Жилдээ
7	Гадаад хэл дээр тогтмол гардаг сонин, сэтгүүл, олон улсад нэвтрүүлгээ цацдаг телевиз, радиотой хамтран	Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулж Улаанбаатар хотыг		МСХ	

	Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг сурталчлах	сурталчилсан байна.			
8	Жуулчдад зориулсан сурталчилгааны видео, танилцуулга, нугалбар, газрын зураг, хөтөч ном зэргийг жил бүр шинэчлэн гаргах	Сурталчилгааны материалуудыг гаргаснаар жуулчид мэдээллээр хангагдах ба гадаад дотоодын үзэсгэлэн болон бусад арга хэмжээнд ашигласан байна.		МСХ	Жилдээ
ТАВ. ҮНДЭСНИЙ БРЭНД БАРАА, БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭГ СУРТАЛЧЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД:					
1	Зочлох үйлчилгээний олон улсын мэргэжлийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах	Салбарын шилдэг мэргэжилтнүүдийг өргөнөөр хамруулсан байна		ЗХ	2-р улирал
2	“Улаанбаатур” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн зохион байгуулах	Хотын аяллын гол бүтээгдэхүүнүүдийг олон нийтэд танилцуулах, хот орчмын тусгай хамгаалалттай газрууд, УБ хот дахь гадаад орнуудын ЭСЯ-д улс орноо сурталчилсан байна		БТХ	2-р улирал
3	Улаанбаатар брэнд бүтээгдэхүүн лого шалгаруулах уралдааныг зохион байгуулж, гадаад дотоодын сурталчилгааны материалд оролцуулах	Улаанбаатар хотын онцлогийг харуулсан үндэсний гар урлалын бүтээгдэхүүн УВ брэнд бий болсон байна.		МСХ	Жилдээ

--oo0oo--